



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 08

Номгон

Засгийн газрын тэргүүлэх чиглэлд тусгагдсан  
“Тэрбум мод”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах”  
арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 31 дүгээр зүйлийн 31.1, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн Засгийн газрын тэргүүлэх чиглэлд тусгагдсан “Тэрбум мод”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг.Сумын Засаг дарга нарт даалгах нь:

1.1.“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төвлөрсөн байршилд 2021 оны намрын улирлаас эхлэн таригдсан моддын тооллого хийж амьдралын хувийг тогтоох, нөхөн тарилтыг зохион байгуулах, тарьсан моддын усалгаа, арчилгааг тарьсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг оролцоог ханган гүйцэтгүүлэх;

1.2.Сумын хэмжээнд намрын мод тарих ажлыг 2024 оны 10 дугаар сарын 01-нээс 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд төвлөрсөн байршилд зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага иргэдийг мод тарих ажилд татан оролцуулах;

1.3.Модлог ургамлын тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, мод тарих аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг стандартын тарьц, суулгацаар

642402013

хангаж, технологийн заавар, зөвлөмж өгөх, тарьц, суулгацын гарал үүсэлд хяналт тавьж ажиллах;

1.4. Сумын хэмжээнд бүх аж ахуйн нэгж, байгууллагуудын эзэмшил газар дахь ногоон байгууламжийн хэмжээг хэмжин тооцож, өөрийн эзэмшлийн газрын 10%-д ногоон байгууламжийг бий болгох мод тарих ажлыг зохион байгуулах хэрэв эзэмшил газрын 10% ногоон байгууламжтай эсхүл ногоон байгууламж бий болгох талбайгүй аж ахуйн нэгж, байгууллагуудыг төвлөрсөн байршилд дүйцэхүйц хэмжээгээр мод тариулах;

1.5. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг тарьсан модоо [www.terbummod.mn](http://www.terbummod.mn) бүртгэлжүүлэх заавар зааварчилгааг сайтар өгч, цахим мэдээллийн санд бүртгэх;

1.6. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мод тарьж буйг цахим хуудас, албан ёсны мэдээллийн эх үүсвэрүүд болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах, бусдадаа үлгэрлэн уриалах, үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;

1.7. Сумын хэмжээнд зохион байгуулсан 2024 оны намрын мод тарих арга хэмжээний тайланг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх;

1.8. Хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүс болон автозам, нийтийн эзэмшлийн талбай дахь хог хаягдлыг цэвэрлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, бүх нийтийн цэвэрлэгээг сар бүр тогтмол зохион байгуулах;

1.8. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, өдөр бүр тогтсон цэгт хаях, хог хаягдал шатаах, автомашин ил задгай угаах, гудамж талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар уриалах болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх хог хаягдлыг бууруулах, нүхэн жорлонг ашиглалтаас хасах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахимаар тогтмол сурталчлах;

1.9. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих, нутаг дэвсгэрийн хэмжээнд хадгалагдаж байгаа аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

1.10. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй шатахуун түгээх станцуудын ашиглаж байгаа нүхэн жорлонг "Шатахуун түгээх станц. Техникийн

ерөнхий шаардлага” MNS4628:2013 стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солиулах, стандартад заасан ариун цэврийн байгууламжтай аж ахуйн нэгжийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

1.11.Сумын нутаг дэвсгэрт хоёрдогч түүхий эд худалдан авдаг, хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг дэмжин түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

1.12.Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалаар батлагдсан “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”-д багтсан 11 нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, ашиглаж буй аж ахуйн нэгжүүдэд үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах талаар чиглэл, шаардлагыг хүргүүлэх;

1.13.Байгаль орчны статистик БОХ-6.1, 6.2, 6.3 тайланг сумын хэмжээнд үнэн, бодитой гаргаж, хугацаанд нь тайлагнах;

1.14.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах;

*Хоёр.Байгаль орчны газарт даалгах нь:*

2.1.“Тэрбум мод” үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулах;

2.2.Аймгийн хэмжээнд намрын мод тарилтаар 350000 ширхэг мод тарих ажлыг зохион байгуулж, сум, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг удирдлагаар ханган, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах;

2.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, өдөр бүр тогтсон цэгт хаях, хог хаягдал шатаах, автомашин ил задгай угаах, гудамж талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар уриалах болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх хог хаягдлыг бууруулах, нүхэн жорлонг ашиглалтаас хасах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахимаар тогтмол сурталчлах;

2.4.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02, 03, 04 дүгээр албан даалгавар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 07 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг 100 хувьд хүргэж тайлаг ирүүлэх;

2.5.Засгийн газрын тэргүүлэх чиглэлд тусгагдсан “Тэрбум мод”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” талаарх сургалт, нөлөөллийн ажил арга хэмжээг бүх төрийн болон хувийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах;

2.6.Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт, албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах;

2.7.Аймгийн намрын мод тарих ажлын тайланг нэгтгэн 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Байгаль орчин, уур амьсгалийн өөрчлөлтийн яам, Ойн газарт хүргүүлэх;

*Гурав.Боловсролын газарт даалгах нь:*

3.1.Бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан байгаль орчныг хамгаалах, мод тарих, хог хаягдлын менежментийн боловсролыг иргэд, олон нийтэд олгох;

3.2.Бага насны хүүхэд, ерөнхий боловсролын сурагчдад **багаас нь хог хаягдлыг** ангилан ялгах дадал хэвшлийг төлөвшүүлэх;

*Дөрөв.“Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазарт даалгах нь:*

4.1.Аймгийн төвийн зам дагуух хашлага хайс болон нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулж, ил задгай хог хаягдалгүй байх;

4.2.Төв, суурин газрын ногоон байгууламжид намрын тарилтыг зохион байгуулж, өвөлжилтөд бэлтгэх;

4.3.Төв, суурин газрын ногоон байгууламжид мал амьтан оруулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

*Тав.“Сум дундын ойн анги” ОНӨТҮГазарт даалгах нь:*

5.1.Модлог ургамлын тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, мод тарих аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг стандартын шаардлага хангасан тарьц, суулгацаар хангаж, технологийн заавар, зөвлөмж өгч ажиллах;

5.2.Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг сайжруулж, тарьц суулгацын нөөцийг нэмэгдүүлэх;

*Зургаа.“Цэвэр хот” ОНӨААТҮГазарт даалгах нь:*

6.1.Хог хаягдлын цэвэрлэгээ, тээвэрлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулж, эрүүл аюулгүй, цэвэр орчин бий болгох;

6.2.Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулж, зөвхөн ангилан ялгасан хог хаягдлыг ачиж байх хэвшлийг бий болгох;

*Долоо.Төрийн болон орон нутгийн өмчит, төсөвт байгууллагын дарга нар болон Аж ахуй нэгж байгууллагуудад:*

7.1."Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд төвлөрсөн байршилд 2021 оны намрын улирлаас эхлэн таригдсан моддын тооллого хийж амьдралын хувийг тогтоох, нөхөн тарилтыг зохион байгуулах, тарьсан моддын усалгаа, арчилгааг тогтмол хийх;

7.2.Өөрийн эзэмшил газар дахь ногоон байгууламжийн хэмжээг хэмжин тооцож, өөрийн эзэмшлийн газрын 10%-д ногоон байгууламжийг бий болгох мод тарих ажлыг зохион байгуулах хэрэв эзэмшил газрын 10% ногоон байгууламжтай эсхүл ногоон байгууламж бий болгох талбайгүй бол төвлөрсөн байршилд дүйцэхүйц хэмжээгээр мод тарих;

7.3.Тарьсан модоо [www.terbummod.mn](http://www.terbummod.mn) цахим мэдээллийн санд бүртгэх;

7.4."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод тарьж буйгаа цахим хуудас, албан ёсны мэдээллийн эх үүсвэрүүдээр дамжуулах, бусдадаа үлгэрлэн уриалах, үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;

7.5.Хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сар бүр сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулах бүх нийтийн цэвэрлэгээнд бүх шатны ажилтан, албан хаагчдыг оролцуулах;

7.6.Өөрийн байгууллага болон орон, байрны гаднах цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, ил задгай хог хаягдалгүй байх;

7.7.Өөрийн байгууллагатаа хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжтой хогийн савыг байршуулах;

7.8.Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хог тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ангилан ялгасан хогийг тээвэрлүүлэх;

7.9.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжийг бүрдүүлж, хогийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин ашиглах;


*Найм.Ард иргэдэд*

8.1.Сум,багаас зохион байгуулсан мод тарих, хог хаягдлын цэвэрлэгээ хийх зэрэг олон нийтийн ажилд идэвхтэй оролцон, хог хаягдлыг ангилан ялгах, ил задгай талбайд хог хаягдлыг асгахгүй байхад анхаарч Үндсэн хуульд заасан иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүлэх;

8.2.Залуу хойч үедээ Байгаль орчноо хамгаалах, хог хаягдлаа ангилан ялгах, ил задгай газар хог хаягдал хаяхгүй байх талаар зөв дадал хэвшүүлэхэд үлгэрлэн ажиллах;

Ес.Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан сар бүрийн 05-ны өдрийн дотор өмнөх сард авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг, холбогдох нотлох баримт, зургийг хавсарган Баянхонгор аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (<https://bayankhongor.igovernment.mn/>)-д тайлагнахыг Сумдын Засаг дарга, Байгаль орчны газар (Д.Содномсамдан), Боловсролын газар (Ж.Алтанцэцэг), “Сум дундын ойн анги” ОНӨТҮГазар (Б.Дэлгэрдалай), “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ (Р.Наранцэцэг), “Цэвэр хот” ОНӨААТҮГ (Ц.Баясгалан), аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Арав.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Мандал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН